


UCS 2101A:2020


ГУДАМЖ ЗАМ, БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН ХАЯГЖИЛТ



Төрийн байгууллагын нэрийн тэмдэг

ГУДАМЖ ЗАМ, БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН ХАЯГЖИЛТ

Төрийн байгууллагын нэрийн тэмдэг



ГАРЧИГ

| | |
|--|----|
| 1. Зорилго | 1 |
| 2. Хамрах хүрээ | 1 |
| 3. Норматив эшлэл..... | 1 |
| 4. Нэр томъёоны тодорхойлолт..... | 1 |
| 5. Үндсэн шаардлага | 2 |
| 6. Нэрийн тэмдгийн бичвэрт тавигдах шаардлага | 3 |
| 7. Төрийн байгууллагын ангилал | 4 |
| 8. Нэрийн тэмдгийн дэвсгэр өнгө | 4 |
| 9. Дээд газар, яамны нэрийн тэмдгийн бичвэр самбарын хэмжээ | 5 |
| 10. Нийслэлийн засаг даргын тамгын газар | 6 |
| 11. Дүүргийн засаг даргын тамгын газар | 7 |
| 12. Материалын шаардлага | 8 |
| 13. Байрлуулах | 8 |
| 14. Суурилуулах | 9 |
| 15. Төрийн байгууллагын нэрийн тэмдгийг хүлээн авах шалгуур үзүүлэлт | 10 |
| Ашигласан материалын жагсаалт | 11 |

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

| | |
|---|---|
| Зураг 1. Төрийн байгууллагын нэрийн тэмдэг | 2 |
| Зураг 2. Төрийн байгууллагын нэрийн тэмдгийн бичвэр | 3 |
| Зураг 3. Алтан шар нэрийн тэмдгийн самбарын загвар, хэмжээ | 5 |
| Зураг 4. Хөх цэнхэр нэрийн тэмдгийн самбарын загвар, хэмжээ | 6 |
| Зураг 5. Мөнгөлөг нэрийн тэмдгийн самбарын загвар, хэмжээ | 7 |
| Зураг 6. Төрийн байгууллагын нэрийн бичвэр, жишиг байршил | 8 |
| Зураг 7. Хаалгатай харьцуулан байрлуулах | 9 |
| Зураг 8. Самбарыг тогтоох хэсэг | 9 |

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

| | |
|---|----|
| Хүснэгт 1. Төрийн байгууллагын ангилал..... | 4 |
| Хүснэгт 2. Нэрийн тэмдгийн өнгө | 4 |
| Хүснэгт 3. Хүлээн авах шалгуур үзүүлэлт | 10 |

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА

Төрийн байгууллагын нэрийн тэмдэг

1. ЗОРИЛГО

Энэхүү баримт бичгийн зорилго нь нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн байгууллагын нэрийн тэмдгийн үндсэн шаардлагыг тогтооход оршино.

2. ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү баримт бичгийг нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн байгууллагын нэрийн тэмдгийг стандартын дагуу үйлдвэрлэх, байрлуулах, суурилуулах үйл ажиллагаанд дагаж мөрдөнө.

3. НОРМАТИВ ЭШЛЭЛ

Энэхүү баримт бичигт дараах эш татсан стандартыг хэрэглэнэ. Эш татсан стандартад өөрчлөлт орсон тохиолдолд тэдгээрийн сүүлийн албан ёсны хэвлэлийг хэрэглэнэ. Үүнд:

1. Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журам (Засгийн газрын 2019 оны 325 дугаар тогтоолын хавсралт)
2. Нийслэлийн засаг даргын 2019 оны А/897 “Гадны хаягийн загвар батлах тухай” захирамж.

4. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

Төрийн алба – гэж төрийн зорилт, чиг үүргийг Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлэх, төрийн бодлого боловсруулах, төрөөс зайлшгүй үзүүлэх шаардлагатай бусад үйлчилгээг нийтэд хүргэх үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалтыг;


Үл хөдлөх эд хөрөнгө – гэж газар, түүнээс салгамагц зориулалтын дагуу ашиглаж үл болох эд юмсыг ойлгоно.

Хаяг – гэж Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, батлагдсан газар зүйн нэр бүхий газар нутаг, хот, суурин газар дахь гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийн байршлыг тодорхойлсон үсэг, тооны илэрхийллийг;

Хаягийн иж бүрдэл – гэж үл хөдлөх эд хөрөнгийн байршлын мэдээллийг шуудангийн нэгдсэн кодын хамт хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системд дэлгэрэнгүй болон товчлол хэлбэрээр бүртгэсэн хаягийн нэгдсэн мэдээллийг;

5. ҮНДСЭН ШААРДЛАГА

5.1. Төрийн байгууллага үйлчилгээгээ иргэдэд ойлгомжтой, чирэгдэлгүй, шуурхай байдлаар тав тухтай орчинд үзүүлэх нөхцөл боломжийг онцгойлон анхаарч үйл ажиллагаа явуулж байгаа барилга болон ажлын байрны гадна талд байгууллагын нэрийн тэмдгийг байршуулна.



Зураг 1. Төрийн байгууллагын нэрийн тэмдэг

- 5.2. Төрийн байгууллагын нэрийн тэмдэг нь нэрийн бичвэр, байгууллагын лого, бэлгэ тэмдэг зэргийг агуулж болох бөгөөд байгууллагын бүтэн нэрийн бичвэр нь Монгол хэл, англи хэл, мөн хуучин Монгол бичгээр гурван төрлөөр бичигдсэн байх ба тэмдгийн дэвсгэр өнгө нь төрийн байгууллагын ангиллаас хамааруулан алтан шар, мөнгөлөг, хөх цэнхэр өнгөтэй байна.
- 5.3. Нэрийн тэмдгийг байгаль цаг уур, ус чийгт тэсвэртэй элэгдэл даах сайн чанарын материалаар хийж суурилуулна.
- 5.4. Төрийн байгууллагын нэрийн тэмдэг хуучирч гандсан, үг үсэг дутуу, тоос шороонд дарагдсан байхыг хориглоно.

6. НЭРИЙН ТЭМДГИЙН БИЧВЭРТ ТАВИГДАХ ШААРДЛАГА

6.1. Нэрийн тэмдэг, мэдээллийн самбар, хаягийн самбарт Сүлд, Соёмбо, Хангарди, байгууллагын логог дүрслэхдээ Төрийн бэлгэ тэмдгийн тухай хууль, Засгийн газрын 2001 оны 41 дүгээр тогтоол, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2004 оны 17 дугаар тогтоолыг тус тус баримтална.



Зураг 2. Төрийн байгууллагын нэрийн тэмдгийн бичвэр

- 6.2. Гадна хаяг болон, нэрийн тэмдгийн бичвэрийг Засгийн газрын 2013 оны 37 дугаар тогтоолын 5 дахь заалт, Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2016 оны 9/10 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтын 2.1 заалтын дагуу Монгол хэл /кирилл/-ээр үг, үсгийн алдаагүй бичих бөгөөд самбарын зүүн талд үндэсний бичгээр бичнэ.
- 6.3. Монгол үндэсний бичгийн бичвэрийн эхний мөр самбарын зах хоорондын зай 6 см байна. Бичвэрийн эхний мөрийг мөр тэтгэж бичих ба үгийн титэм, шилбэ, гэдэс, нум, орхиц, сүүл зэрэг зурлага нь өмнөх болон дараах мөрний үг, үсэгт тулахааргүй бичигдсэн байна.
- 6.4. Төрийн байгууллагын нэрийн англи хэл дээрх бичвэр нь Монгол /кирилл/ бичвэрийн доор байрлах ба түүнээс хоёр дахин бага өндөртэй байна.
- 6.5. Байгууллагын нэрийн тэмдэгтийн тоо, хэмжээнээс шалтгаалан нэрийн бичвэрийн самбарын хэмжээ хамгийн ихдээ өндөр нь 70 см, өргөн нь 120 см байх ба нэрийн бичвэрийн үсгийн өндөр, үг, үсэг, лого, бэлэг тэмдгийн хоорондын зай, хэмжээг өөрчлөхгүй.

7. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН АНГИЛАЛ

7.1. Нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн байгууллагуудыг дараах байдлаар ангилна. Үүнд:

Хүснэгт 1. Төрийн байгууллагын ангилал

| № | Байгууллагын ангилал | Хамаарах байгууллагууд /Жишээ/ |
|---|---|--|
| 1 | Дээд газар, Яам түүний харьяа газар | Сангийн яам ... гэх мэт |
| 2 | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд | Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид, Нийслэлийн засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Улаанбаатар хотын Захирагчийн харьяа байгууллага, Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг |
| 3 | Дүүргийн Засаг даргын тамгын газар, түүний харьяа байгууллага | Дүүргийн Засаг даргын тамгын газар, хэлтэс, алба, харьяа байгууллага |

8. НЭРИЙН ТЭМДГИЙН ДЭВСГЭР ӨНГӨ

8.1. Төрийн байгууллагуудын нэрийн тэмдгийн дэвсгэр өнгө нь байгууллагын ангиллаас хамааруулан алтан шар, мөнгөлөг, хөх цэнхэр өнгөтэй байх бөгөөд дараах байдлаар авч хэрэглэнэ.

Хүснэгт 2. Нэрийн тэмдгийн өнгө

| № | Байгууллагын ангилал | Нэрийн тэмдэгний өнгө | Өнгөний код |
|---|---|---|---|
| 1 | Дээд газар, Яам түүний харьяа газар |  | HTML /CSS/ Алтан шар, Metallic gold/ Hex Code #RRGGBB /#D4AF37/ Decimal Code R,G,B /212,175,55/ |
| 2 | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд |  | HTML /CSS/ Хөх цэнхэр, blue Hex Code #RRGGBB /#0000FF/ Decimal Code R,G,B /0,0,255/ |
| 3 | Дүүргийн Засаг даргын тамгын газар, түүний харьяа байгууллага |  | HTML /CSS /Мөнгөлөг, Silver/ Hex Code #RRGGBB /#C0C0C0/ Decimal Code R,G,B /192,192,192/ |

9. ДЭЭД ГАЗАР, ЯАМНЫ НЭРИЙН ТЭМДГИЙН БИЧВЭР САМБАРЫН ХЭМЖЭЭ




Зураг 3. Алтан шар нэрийн тэмдгийн самбарын загвар, хэмжээ

- 9.1. Хүрээ нь захаасаа 1 см зайд 0,5 см өргөн хар өнгөтэй байна.
- 9.2. Самбарын өндөр нь 45-70 см, өргөн нь 70-120 см, харьцаа нь $70/45=1.6$ буюу 1.6-1.9 хооронд байна.
- 9.3. Монгол кирилл бичвэрийг голлуулж дээд дунд хэсэгт 13x13 см хэмжээтэй дүүргийн лого болон нийслэлийн бэлэг тэмдэг болох Хангарди логог байрлуулна. Соёмбыг 16x16 хэмжээнд байрлуулна.
- 9.4. Хаягийг шөнийн цагаар харагдахуйц гэрэлтүүлэгтэй байрлуулна.
- 9.5. Монгол кирилл үсгийн хэвжүүлэлд arial narrow шрифтээр 4,5 см өндөртэй бүх үсгийг томоор бичнэ.
- 9.6. Монгол үндэсний бичгийн бичвэрийн эхний мөр самбарын зүүн зах хоорондын зай байгууллагын нэрийн тэмдэгтээс хамааран 5 см-ээс 6 см байна.
- 9.7. Монгол үндэсний бичгийн бичвэрийн мөр хоорондын зай 6 см байна.
- 9.8. Гадаад үсгийн хэвжүүлэлд arial narrow шрифтээр Монгол кирилл бичиглэлээс 2 дахин бага хэмжээтэй байна.

10. НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

10.1. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид, Нийслэлийн засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Улаанбаатар хотын Захирагчийн харьяа байгууллага, Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг, харьяа байгууллагын нэрийн тэмдгийн самбарын загвар, хэмжээг Зураг 4-т үзүүлэв.



Зураг 4. Хөх цэнхэр нэрийн тэмдгийн самбарын загвар, хэмжээ

- 10.2. Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид, Нийслэлийн засаг даргын тамгын газар, Улаанбаатар хотын захирагчийн ажлын алба, Улаанбаатар хотын захирагчийн харьяа байгууллага, Нийслэлийн засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг, харьяа байгууллагууд;
- 10.3. Хүрээ нь захаасаа 1 см зайд 0,5 см өргөн хар өнгөтэй байна.
- 10.4. Самбарын өндөр нь 45-70 см, өргөн нь 70-120 см, харьцаа нь $70/45=1.6$ буюу 1.6-1.9 хооронд байна.
- 10.5. Монгол кирилл бичвэрийг голлуулж дээд дунд хэсэгт 13x13 см хэмжээтэй дүүргийн лого болон нийслэлийн бэлэг тэмдэг болох Хангарди логог байрлуулна. Соёмбыг 16x16 хэмжээнд байрлуулна.
- 10.6. Хаягийг шөнийн цагаар харагдахуйц гэрэлтүүлэгтэй байрлуулна.
- 10.7. Монгол кирилл үсгийн хэвжүүлэлд arial narrow шрифтээр 4,5 см өндөртэй бүх үсгийг томоор бичнэ.
- 10.8. Монгол үндэсний бичгийн бичвэрийн эхний мөр самбарын зүүн зах хоорондын зай байгууллагын нэрийн тэмдэгтээс хамааран 5 см-ээс 6 см байна.
- 10.9. Монгол үндэсний бичгийн бичвэрийн мөр хоорондын зай 6 см байна.
- 10.10. Гадаад үсгийн хэвжүүлэлд arial narrow шрифтээр Монгол кирилл бичиглэлээс 2 дахин бага хэмжээтэй байна.

11. ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

11.1. Дүүргийн Засаг даргын тамгын газар, хэлтэс, харьяа байгууллагын нэрийн тэмдгийн самбарын загвар, хэмжээг Зураг 5-т үзүүлэв.




Зураг 5. Мөнгөлөг нэрийн тэмдгийн самбарын загвар, хэмжээ

- 11.2. Хүрээ нь захаасаа 1 см зайд 0,5 см өргөн хар өнгөтэй байна.
- 11.3. Самбарын өндөр нь 45-70 см, өргөн нь 70-120 см, харьцаа нь $70/45=1.6$ буюу 1.6-1.9 хооронд байна.
- 11.4. Монгол кирилл бичвэрийг голлуулж дээд дунд хэсэгт 13x13 см хэмжээтэй дүүргийн лого болон нийслэлийн бэлэг тэмдэг болох Хангарди логог байрлуулна. Соёмбыг 16x16 хэмжээнд байрлуулна.
- 11.5. Хаягийг шөнийн цагаар харагдахуйц гэрэлтүүлэгтэй байрлуулна.
- 11.6. Монгол кирилл үсгийн хэвжүүлэлд arial narrow шрифтээр 4,5 см өндөртэй бүх үсгийг томоор бичнэ.
- 11.7. Монгол үндэсний бичгийн бичвэрийн эхний мөр самбарын зүүн зах хоорондын зай байгууллагын нэрийн тэмдэгтээс хамааран 5 см-ээс 6 см байна.
- 11.8. Монгол үндэсний бичгийн бичвэрийн мөр хоорондын зай 6 см байна.
- 11.9. Гадаад үсгийн хэвжүүлэлд arial narrow шрифтээр Монгол кирилл бичиглэлээс 2 дахин бага хэмжээтэй байна.

12. МАТЕРИАЛЫН ШААРДЛАГА

12.1. Нэрийн тэмдгийн материал, дэвсгэр өнгө, бичвэр нь аливаа байгалийн үзэгдэлд тэсвэртэй, хуурч гандахгүй, зэвэрдэггүй өнгөт ган төмөр байх бөгөөд хамгаалалтын гадаргуутай байна.



13. БАЙРЛУУЛАХ


13.1. Төрийн байгууллагын нэрийн тэмдгийг барилга байгууламжийн нүүрэн талд, нийтэд харагдахуйц байрлуулах ба орох, гарах хаалгатай ойролцоо байрлуулна.

13.2. Нэг барилга байгууламжид хэд хэдэн байгууллага, аж ахуй нэгж байрлан үйл ажиллагаа явуулж байгаа тохиолдолд байгууллагын нэрийг барилга байгууламжийн гадна болон дотор талд мэдээллийн самбарт байрлуулах бөгөөд байгууллагын нэрийн тэмдгийг үйл ажиллагаа явуулж буй давхарт, зөвхөн өрөөнд үйл ажиллагаа явуулж байгаа тохиолдолд хаалганы гадна орох талын баруун гар талд байрлуулна.

13.3. Төрийн байгууллагын нэрийн тэмдэг байрлуулах жишиг засварыг Зураг 6, 7-т үзүүлэв.



Зураг 6. Төрийн байгууллагын нэрийн бичвэр, жишиг байршил



Зураг 7. Хаалгатай харьцуулан байрлуулах

14. СУУРИЛУУЛАХ

- 14.1. Нэрийн тэмдгийн самбарыг байрлуулах, суурилуулахдаа орчны аюулгүй байдлыг хангах зорилгыг урьтал болгоно.
- 14.2. Нэрийн тэмдгийг салхинд унахгүйгээр бат бөх, чанарын стандарт, шаардлага хангасан байх бөгөөд олон нийтийн гэмтэх эрсдэлийг тооцоолсны үндсэн дээр суурилуулна.
- 14.3. Нэрийн тэмдгийг зохих гадаргууд силикон цавуугаар нааж, шаардлагатай тохиолдолд тэлэгчтэй шрүп, боолтоор тогтоож болно.



Тогтоож бэхлэх хэсэг

Зураг 8. Самбарыг тогтоох хэсэг

15. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН НЭРИЙН ТЭМДГИЙГ ХҮЛЭЭН АВАХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Барилга байгууламж, үл хөдлөх хөрөнгийг хаягжуулах ажил -хаягийн бичвэр, тэмдэгт тавигдаж байгаа материалын шаардлага, хэмжээ, загвар, байрлуулах, суурилуулах шаардлагыг хангаж байгаа эсэхийг хүлээн авах шалгуур үзүүлэлт (Хүснэгт 3.)-ийн дагуу хянан шалгаж хүлээн авна.

Хүснэгт 3. Хүлээн авах шалгуур үзүүлэлт

| № | Шалгуур үзүүлэлт | Тийм | Үгүй |
|---|---|--------------------------|--------------------------|
| 1 | Байгууллагын нэр тэмдгийн мэдээлэл тохирч байгаа эсэх? | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 2 | Тэмдгийн бичвэр үг, үсгийн алдаагүй зай хэмжээний шаардлага хангаж байгаа эсэх? | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 3 | Тэмдгийн хэмжээ стандартын шаардлага хангаж байна уу? | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 4 | Өнгө, гэрэл ойлголт стандарт шаардлага хангаж байгаа эсэх | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 5 | Тэмдгийг зөв байршилд байрлуулсан эсэх? | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 6 | Тэмдгийн суурилуулалт бэхэлгээ шаардлага хангаж байгаа эсэх? | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |

Тайлбар: Барилга байгууламж, үл хөдлөх хөрөнгийн хаягийн нь дээрх бүх шаардлагыг хангаж байх ёстой бөгөөд шаардлага хангасан бол “Тийм” хийгдээгүй буюу хийгдсэн боловч шаардлага хангахгүй байгаа бол “Үгүй” хэсгийг тэмдэглэнэ.

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

- Хаягжуулалтын тухай хууль;
- Монгол хэл бичгийн боловсролыг сайжруулах арга хэмжээний тухай (ЗГ-ын 37-р тогтоол, 2013 он)
- Гадна зар сурталчилгаанд тавих шаардлага (Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 9/10 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт)
- Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журам (Засгийн газрын 2019 оны 325 дугаар тогтоолын хавсралт)



Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг
ХОТЫН СТАНДАРТ, ОРЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН
ХЯНАЛТ ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР



Хангарди ордон, Ц.Жигжиджавын гудамж -7/1
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160-0011



7011-8060



www.standart.ub.gov.mn



Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт,
зохицуулалтын газар